

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/258 дугаар
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2025 он

БАТЛАВ: ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ж. ОТГОНБААТАР

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах

Тендер
шалгаруулалтын
дугаар:

ЭХЭМҮТ/2025010202001/01/01

Боловсруулсан: Үнэлгээний хорооны дарга
Үнэлгээний хорооны нарийн бичиг
Гишүүн

Хөндлөнгийн гишүүн

Э.Бямбасүрэн
В.Оюунгэрэл
Д.Хонгорзул
М.Ундрэм
Х.Наранчимэг
Н.Уранцэцэг
Ц.Дарханбат
Т.Мөнхзаяа
Э.Жавхлан

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ).....	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж.....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	3
11. Тендерийн иж бүрдэл	4
12. Тендерийн жишиг маягтууд.....	5
13. Хувилбарт санал.....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг.....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт.....	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	8
20. Тендерийн валют	9
21. Тендер хүчинтэй байх хугацаа	9
22. Тендерийн баталгаа.....	9
23. Тендер баталгаажуулах, илгээх.....	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	10
25. Тендерийн талаар тодруулга авах	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх	10
27. Тендерийг үнэлэх.....	10
28. Арифметик алдааг залруулах.....	10
29. Оролцогчид давуу эрх олгох	11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт.....	11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	11
32. Тендерийг эрэмбэлэх.....	11

33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	11
34.	Мэдэгдэл хүргүүлэх.....	11
35.	Гүйцэтгэлийн баталгаа	12
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	12

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|--|---|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.</p> <p>1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | <p>2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.</p> |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж | <p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> |
| 4. Худалдан авах ажиллагааны цахим систем | <p>4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.</p> |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх | <p>5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p> |

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч** **этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Б. АГУУЛГА

**9. Тендер
шалгаруулалтын
баримт бичиг**

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

**10. Тендер
шалгаруулалтын
баримт бичгийг
тодруулах**

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

**11. Тендер ирүүлэхийн
өмнөх уулзалт**

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

**12. Тендер
шалгаруулалтын
баримт бичгийн
болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
 - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
 - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
 - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
 - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
 - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
 - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
 - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
 - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
 - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

		13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
		13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
14. Тендерийн маягтууд	жишиг	14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
15. Хувилбарт санал		15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг		16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ. 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ. 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ: 16.3.1. Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг; 16.3.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг; 16.3.3. Тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг. 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг		17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ. 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

- | | |
|---|--|
| 31. Давуу эрх олгох | <p>31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.</p> <p>31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.</p> <p>31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.</p> |
| 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт | <p>32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.</p> |
| 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох | <p>33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.</p> <p>33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.</p> <p>33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.</p> |
| 34. Тендерийг эрэмбэлэх | <p>34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.</p> |
| 35. Оролцогчийн чадавхыг магадлах дахин | <p>35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.</p> <p>35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.</p> <p>35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.</p> |

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- | | |
|------------------------------|--|
| 36. Шийдвэр хүргүүлэх | <p>36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.</p> |
|------------------------------|--|

**37. Гүйцэтгэлийн
баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг
зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, УРВАЛЖ БОДИС ХУДАЛДАН АВАХ
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ЭХЭМҮТ/20250102001/01/01

ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:	
	Багцын дугаар	Багцын нэр
	Багц 1	Антибиотик 1
	Багц 2	Антибиотик 2
	Багц 3	Антибиотик 3
	Багц 4	Антибиотик 4
	Багц 5	Бүлэгнэлтийн фактор
	Багц 6	Умайн булчинд нөлөөлөх эм 1
	Багц 7	Умайн булчинд нөлөөлөх эм 2
	Багц 8	Умайн булчинд нөлөөлөх эм 3
	Багц 9	Өвдөлт намдаах эмүүд 1
	Багц 10	Эмэгтэйчүүдийн лаа
	Багц 11	Цус бүлэгнэлт, төлжилтийн эмүүд
	Багц 12	Бүлэгнэлтэнд нөлөөлөх эмүүд
	Багц 13	Мэдээгүйжүүлэг тойрны эмүүд
	Багц 14	Дэгдэмхий мэдээгүйжүүлгийн эм 1
	Багц 15	Дэгдэмхий мэдээгүйжүүлгийн эм 2
	Багц 16	Дотоод шүүрлийн эмгэгийн эмүүд
	Багц 17	Гормоны бэлдмэл
	Багц 18	Уургийн бэлдмэл
	Багц 19	Интерферон
	Багц 20	Зүрх, судасны эмүүд 1
	Багц 21	Зүрх, судасны эмүүд 2
	Багц 22	Судсаар тэжээх уусмал
	Багц 23	Дутуу нярайн судсаар тэжээх уусмал
	Багц 24	Мэдрэлийн эмгэгийн эм
	Багц 25	Таталтын эсрэг эмүүд
	Багц 26	Витамин
	Багц 27	Дутуу нярайд хэрэглэх эмүүд
	Багц 28	Амьсгалын эрхтэний эмгэгийн эмүүд
	Багц 29	Хоол боловсруулах эрхтэний эмгэгийн эм 1
	Багц 30	Хоол боловсруулах эрхтэний эмгэгийн эм 2
	Багц 31	Элэгний шилжүүлэх мэс заслын үеийн эмүүд
	Багц 32	Тодосгогч бодис 1
	Багц 33	Тодосгогч бодис 2
	Багц 34	Тодосгогч бодис 3
	Багц 35	Нүдний дусаалга
	Багц 36	Чих хамар хоолойн дусаалга
	Багц 37	Арьсны тос, гель
	Багц 38	Бусад эм 1
	Багц 39	Бусад эм 2
	Багц 40	Дархлаа дарангуйлах эмүүд
	Багц 41	Хавдрын эсрэг эм 1
	Багц 42	Хавдрын эсрэг эм 2
	Багц 43	Дотоодын эм
	Багц 44	Тарилгын шингэн
	Багц 45	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмүүд
	Багц 46	Формалин
	Багц 47	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 1
	Багц 48	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 2
	Багц 49	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 3
	Багц 50	Дурангийн ариутгалын бодис
	Багц 51	Багаж ариутгах уут, боолт

	Багц 52	Ариутгалын тест, багаж угаах хэрэгсэл
	Багц 53	Эмнэлгийн хэрэгсэл 1
	Багц 54	Эмнэлгийн хэрэгсэл 2
	Багц 55	Ургийн мониторын цаас
	Багц 56	Ариун самбай
	Багц 57	Мэс засал, кесар хагалгааны иж бүрдэл
	Багц 58	Мэс заслын бээлий
	Багц 59	Үзлэгийн бээлий
	Багц 60	Тариур
	Багц 61	Тариур, зүү
	Багц 62	Уян зүү, гуурс
	Багц 63	Дуслын систем
	Багц 64	Мэс заслын наалтууд
	Багц 65	Гуурс
	Багц 66	Интубацийн гуурс
	Багц 67	Гуурс 2
	Багц 68	Амьсгалын замын хэрэгсэл
	Багц 69	Үр хөндөлтийн ажилбарын хэрэгсэл
	Багц 70	Биопсийн зүү, хэрэгсэл
	Багц 71	Аюулгүйн хайрцаг
	Багц 72	Цус тогтоох хэрэгсэл
	Багц 73	Мэс засал, хагалгааны хэрэгсэл
	Багц 74	Дижитал рентген хальс 1
	Багц 75	Дижитал рентген хальс 2
	Багц 76	Мэдээгүйжүүлгийн маск, хэрэгсэл
	Багц 77	Мэс заслын утас 1
	Багц 78	Мэс заслын утас 2
	Багц 79	Мэс заслын утас 3
	Багц 80	Мэс заслын утас 4
	Багц 81	Мэс заслын утас 5
	Багц 82	Шүдний материал
	Багц 83	Шүдний багаж хэрэгсэл
	Багц 84	Эрүү нүүрний гажиг заслын хэрэгсэл
	Багц 85	Гемодиализийн хэрэгсэл
	Багц 86	Хэвлийн диализийн гуурс хэрэгсэл
	Багц 87	Диализын тунел гуурс
	Багц 88	Дурангийн мэс заслын хэрэгсэл
	Багц 89	Ерөнхий мэс заслын хэрэгсэл 1
	Багц 90	Ерөнхий мэс заслын хэрэгсэл 2
	Багц 91	Ерөнхий мэс заслын хэрэгсэл 3
	Багц 92	Ерөнхий мэс заслын хэрэгсэл 4
	Багц 93	Тэлэгч баллон, хэрэгсэл
	Багц 94	Хүүхдийн дурангийн хэрэгсэл
	Багц 95	Ангиографийн хэрэгсэл
	Багц 96	Эрүү нүүрний мэс заслын хэрэгсэл
	Багц 97	Чих хамар хоолойн мэс заслын хэрэгсэл
	Багц 98	Тархины мэс заслын хэрэгсэл
	Багц 99	Цээжний мэс заслын хэрэгсэл
	Багц 100	Нүдний мэс заслын хэрэгсэл
	Багц 101	Торлогын мэс заслын хэрэгсэл
	Багц 102	Нүдний даралт хэмжих аппаратын хэрэгсэл
	Багц 103	Бөөрний мэс заслын хэрэгсэл
	Багц 104	Элэгний мэс заслын хэрэгсэл 1
	Багц 105	Элэгний мэс заслын хэрэгслүүд 2

	Багц 106	Элэгний мэс заслын хэрэгслүүд 3
	Багц 107	Зүрхний мэс заслын хэрэгсэл
	Багц 108	Дуслын шахуурганы систем
	Багц 109	Хими эмчилгээний гуурс
	Багц 110	Тархины цахилгаан бичлэгийн аппаратын гель
	Багц 111	Эмэгтэйчүүдийн ажилбарын хэрэгсэл
	Багц 112	Эмэгтэйчүүдийн хэрэгсэл
	Багц 113	Ургийн мэс заслын хэрэгсэл
	Багц 114	Нүдний шилний бэлдэц, хүрээ
	Багц 115	Өвчтөний бугуйвч, хэвлэх төхөөрөмж
	Багц 116	Вакуумтейнер
	Багц 117	Элэгний мэс заслын урвалж
	Багц 118	Гастростомын гуурс
	Багц 119	Иммунологи-биохимийн бүрэн автомат анализаторын урвалж
	Багц 120	Иммунологийн бүрэн автомат анализаторийн урвалж 1
	Багц 121	Иммунологийн бүрэн автомат анализаторийн урвалж 2
	Багц 122	Биохимийн бүрэн автомат анализаторын урвалж
	Багц 123	Биохими-бүлэгнэлт-шээсний бүрэн автомат анализаторын урвалж
	Багц 124	Гематологийн бүрэн автомат анализаторийн урвалж
	Багц 125	Микробиологийн урвалж 1
	Багц 126	Микробиологийн урвалж 2
	Багц 127	Лабораторийн дагалдах хэрэгсэл 1
	Багц 128	Лабораторийн дагалдах хэрэгсэл 2
	Багц 129	RNA/DNA ялгах болон дагалдах хэрэгслүүд
	Багц 130	Иммунофенотипийн шинжилгээний урвалж
	Багц 131	Иммуногистохимийн урвалж
	Багц 132	Үргүйдлийн лабораторийн зүү, гуурс
	Багц 133	Үргүйдлийн лабораторийн хэрэгсэл
	Багц 134	Үргүйдлийн лабораторийн урвалж
	Багц 135	Пренатал илрүүлэг
	Багц 136	Цитогенетик шинжилгээний урвалж
	Багц 137	Цитогенетик шинжилгээний хэрэгсэл
	Багц 138	Лабораторийн химийн урвалж бодис
	Багц 139	Амьсгалын аппаратны хэрэгсэл
	Багц 140	Хяналтын мониторийн хэрэгсэл
	Багц 141	Томуугийн ялган оношлох түргэвчилсэн тест
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич:	
	<i>Багц № 43</i>	<i>Дотоодын эм</i>
	<i>Багц № 44</i>	<i>Тарилгын шингэн (Дотоод багц)</i>
	<i>Багц № 47</i>	<i>Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 1 (Дотоод багц)</i>
	<i>Багц № 48</i>	<i>Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 2 (Дотоод багц)</i>
	<i>Багц № 57</i>	<i>Мэс засал, кесар хагалгааны иж бүрдэл (Дотоод багц)</i>
	<i>Багц № 60</i>	<i>Тариур (Дотоод багц)</i>
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”	
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Эрүүл мэндийн даатгалын сан	

ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 14,000,000,000 (Арван дөрвөн тэрбум төгрөг)		
	Багцын дугаар	Төсөвт өртөг	Багцын төсөвт өртөг (төгрөгөөр)
	Багц 1	34,536,000.0	Гучин дөрвөн сая таван зуун гучин зургаан мянган төгрөг
	Багц 2	104,167,200.0	Нэг зуун дөрвөн сая нэг зуун жаран долоон мянга хоёр зуун төгрөг
	Багц 3	175,680,000.0	Нэг зуун далан таван мянга зургаан зуун наян төгрөг
	Багц 4	20,284,500.0	Хорин сая хоёр зуун наян дөрвөн мянга таван зуун төгрөг
	Багц 5	227,200,000.0	Хоёр зуун хорин долоон сая хоёр зуун төгрөг
	Багц 6	28,320,000.0	Хорин найман сая гурван зуун хорин мянган төгрөг
	Багц 7	67,200,000.0	Жаран долоон сая хоёр зуун төгрөг
	Багц 8	22,680,000.0	Хорин хоёр сая зургаан зуун наян мянган төгрөг
	Багц 9	43,632,000.0	Дөчин гурван сая зургаан зуун гучин хоёр мянган төгрөг
	Багц 10	18,960,000.0	Арван найман сая есөн зуун жаран мянган төгрөг
	Багц 11	67,440,000.0	Жаран долоон сая дөрвөн зуун дөчин мянган төгрөг
	Багц 12	65,914,600.0	Жаран таван сая есөн зуун арван дөрвөн мянга зургаан зуун төгрөг
	Багц 13	28,732,800.0	Хорин найман сая долоон зуун гучин хоёр мянга найман зуун төгрөг
	Багц 14	304,920,000.0	Гурван зуун дөрвөн сая есөн зуун хорин мянган төгрөг
	Багц 15	20,160,000.0	Хорин сая нэг зуун жаран мянган төгрөг
	Багц 16	330,242,000.0	Гурван зуун гучин сая хоёр зуун дөчин хоёр мянган төгрөг
	Багц 17	30,031,200.0	Гучин сая гучин нэгэн мянга хоёр зуун төгрөг
	Багц 18	61,440,000.0	Жаран нэгэн сая дөрвөн зуун дөчин мянган төгрөг
	Багц 19	10,636,600.0	Арван сая зургаан зуун гучин зургаан мянга зургаан зуун төгрөг
	Багц 20	23,326,200.0	Хорин гурван сая гурван зуун хорин зургаан мянга хоёр зуун төгрөг
	Багц 21	36,151,500.0	Гучин зургаан сая нэг зуун тавин нэгэн мянга таван зуун төгрөг
	Багц 22	198,369,600.0	Нэг зуун ерэн найман сая гурван зуун жаран есөн мянга зургаан зуун төгрөг
	Багц 23	174,000,000.0	Нэг зуун далан дөрвөн сая төгрөг
	Багц 24	72,214,400.0	Далан хоёр сая хоёр зуун арван дөрвөн мянга дарван зуун төгрөг
	Багц 25	25,347,000.0	Хорин таван сая гурван зуун дөчин долоон мянган төгрөг
	Багц 26	5,511,460.0	Таван сая таван зуун арван нэгэн мянга дөрвөн зуун жаран төгрөг
	Багц 27	424,107,200.0	Дөрвөн зуун хорин дөрвөн сая нэг зуун долоон мянга хоёр зуун төгрөг
	Багц 28	3,585,600.0	Гурван сая таван зуун наян таван мянга зургаан зуун төгрөг
	Багц 29	71,271,620.0	Далан нэгэн сая хоёр зуун далан нэгэн мянга зургаан зуун хорин төгрөг
	Багц 30	72,212,000.0	Далан хоёр сая хоёр зуун арьан хоёр мянган төгрөг
	Багц 31	17,019,300.0	Арван долоон сая арван есөн мянга гурван зуун төгрөг
	Багц 32	50,582,400.0	Тавин сая таван зуун наян хоёр мянга дөрвөн зуун төгрөг
	Багц 33	46,615,680.0	Дөчин зургаан сая зургаан зуун арван таван мянга зургаан зуун наян төгрөг

	Багц 34	49,920,000.0	Дөчин есөн сая есөн зуун хорин мянган төгрөг
	Багц 35	28,351,630.0	Хорин найман сая гурван зуун тавин нэгэн мянга зургаан зуун гучин төгрөг
	Багц 36	7,531,440.0	Долоон сая таван зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун дөчин төгрөг
	Багц 37	9,085,920.0	Есөн сая наян таван мянга есөн зуун хорин төгрөг
	Багц 38	38,440,800.0	Гучин найман сая дөчин дөрвөн мянга найман зуун төгрөг
	Багц 39	11,611,700.0	Арван нэгэн сая зургаан зуун арван нэгэн мянга долоон зуун төгрөг
	Багц 40	38,416,000.0	Гучин найман сая дөрвөн зуун арван зургаан мянган төгрөг
	Багц 41	53,391,200.0	Тавин гурван сая гурван зуун ерэн нэгэн мянга хоёр зуун төгрөг
	Багц 42	58,124,000.0	Тавин найман сая нэг зуун хорин дөрвөн мянган төгрөг
	Багц 43	66,967,560.0	Жаран зургаан сая есөн зуун жаран долоон мянга таван зуун жаран төгрөг
	Багц 44	189,680,300.0	Нэг зуун наян есөн сая зургаан зуун наян мянга гурван зуун төгрөг
	Багц 45	18,765,120.0	Арван найман сая долоон зуун жаран таван мянга нэг зуун хорин төгрөг
	Багц 46	138,240,000.0	Нэг зуун гучин найман сая хоёр зуун дөчин мянган төгрөг
	Багц 47	81,523,200.0	Наян нэгэн сая таван зуун хорин гурван мянга хоёр зуун төгрөг
	Багц 48	39,872,680.0	Гучин есөн сая найман зуун далан хоёр мянга зургаан зуун наян төгрөг
	Багц 49	84,586,000.0	наян дөрвөн сая таван зуун наян зургаан мянган төгрөг
	Багц 50	22,800,000.0	Хорин хоёр сая найман зуун төгрөг
	Багц 51	21,180,000.0	Хорин нэгэн сая нэг зуун наян мянган төгрөг
	Багц 52	22,700,000.0	Хорин хоёр сая долоон зуун мянган төгрөг
	Багц 53	120,790,000.0	Нэг зуун хорин сая долоон зуун ерэн мянган төгрөг
	Багц 54	119,138,580.0	Нэг зуун арван есөн сая нэг зуун гучин найман мянга таван зуун төгрөг
	Багц 55	42,781,600.0	Дөчин хоёр сая долоон зуун наян нэгэн мянга зургаан зуун төгрөг
	Багц 56	386,054,400.0	Гурван зуун наян зургаан сая тавин дөрвөн мянга дөрвөн зуун төгрөг
	Багц 57	557,000,000.0	Таван зуун тавин долоон сая төгрөг
	Багц 58	136,032,000.0	Нэг зуун гучин зургаан сая гучин хоёр мянган төгрөг
	Багц 59	186,176,000.0	Нэг зуун наян зургаан сая нэг зуун далан зургаан мянган төгрөг
	Багц 60	351,504,000.0	Гурван зуун тавин нэгэн сая таван зуун дөрвөн мянган төгрөг
	Багц 61	26,505,600.0	Хорин зургаан сая таван зуун таван мянга зургаан зуун төгрөг
	Багц 62	151,468,000.0	Нэг зуун тавин нэгэн сая дөрвөн зуун жаран найман мянган төгрөг
	Багц 63	172,324,800.0	Нэг зуун далан хоёр сая гурван зуун хорин дөрвөн мянга найман зуун төгрөг
	Багц 64	32,329,200.0	Гучин хоёр сая гурван зуун хорин есөн мянга хоёр зуун төгрөг
	Багц 65	88,980,640.0	Наян найман сая есөн зуун наян мянга зургаан зуун дөчин төгрөг
	Багц 66	71,907,400.0	Далан нэгэн сая есөн зуун долоон мянга дөрвөн зуун төгрөг
	Багц 67	64,372,320.0	Жаран дөрвөн сая гурван зуун далан хоёр мянга гурван зуун хорин төгрөг

	Багц 68	48,722,100.0	Дөчин найман сая долоон зуун хорин хоёр мянга нэг зуун төгрөг
	Багц 69	20,177,000.0	Хорин сая нэг зуун далан долоон мянган төгрөг
	Багц 70	42,376,000.0	Дөчин хоёр сая гурван зуун далан зургаан мянган төгрөг
	Багц 71	30,288,000.0	Гучин сая хоёр зуун наян найман мянган төгрөг
	Багц 72	10,246,000.0	Арван сая хоёр зуун дөчин зургаан мянган төгрөг
	Багц 73	28,770,000.0	Хорин найман сая долоон зуун далан мянган төгрөг
	Багц 74	26,370,000.0	Хорин зургаан сая гурван зуун далан мянган төгрөг
	Багц 75	43,127,100.0	Дөчин гурван мянга нэг зуун хорин долоон мянга нэг зуун төгрөг
	Багц 76	71,869,000.0	Далан нэгэн сая найман зуун жаран есөн мянган төгрөг
	Багц 77	197,161,760.0	Нэг зуун ерэн долоон сая нэг зуун жаран нэгэн мянга долоон зуун жаран төгрөг
	Багц 78	60,256,000.0	Жаран сая хоёр зуун тавин зургаан мянган төгрөг
	Багц 79	72,960,000.0	Далан хоёр сая есөн зуун жаран мянган төгрөг
	Багц 80	131,000,000.0	Нэг зуун гучин нэгэн сая төгрөг
	Багц 81	20,316,000.0	Хорин сая гурван зуун арван зургаан мянган төгрөг
	Багц 82	104,468,880.0	Нэг зуун дөрвөн сая дөрвөн зуун жаран найман мянга найман зуун наян төгрөг
	Багц 83	10,578,600.0	Арван сая таван зуун далан найман мянга зургаан зуун төгрөг
	Багц 84	45,072,700.0	Дөчин таван сая далан хоёр мянга долоон зуун төгрөг
	Багц 85	230,027,200.0	Хоёр зуун гучин сая хорин долоон мянга хоёр зуун төгрөг
	Багц 86	6,542,000.0	Зургаан сая таван зуун дөчин хоёр мянган төгрөг
	Багц 87	27,000,000.0	Хорин долоон сая төгрөг
	Багц 88	206,340,000.0	Хоёр зуун зургаан сая гурван зуун дөчин мянган төгрөг
	Багц 89	56,884,000.0	Тавин зургаан сая найман зуун наян дөрвөн мянган төгрөг
	Багц 90	60,280,000.0	Жаран сая хоёр зуун наян мянган төгрөг
	Багц 91	102,600,000.0	Нэг зуун хоёр сая зургаан зуун мянган төгрөг
	Багц 92	20,000,000.0	Хорин сая төгрөг
	Багц 93	74,500,000.0	Далан дөрвөн сая таван зуун мянган төгрөг
	Багц 94	82,315,000.0	Наян хоёр сая гурван зуун арван таван мянган төгрөг
	Багц 95	368,156,000.0	Гурван зуун жаран найман сая нэг зуун тавин зургаан мянган төгрөг
	Багц 96	16,570,000.0	Арван зургаан сая таван зуун далан мянган төгрөг
	Багц 97	758,169,080.0	Долоон зуун тавин найман сая нэг зуун жаран есөн мянга наян төгрөг
	Багц 98	13,480,000.0	Арван гурван сая дөрвөн зуун наян мянган төгрөг
	Багц 99	130,421,920.0	Нэг зуун гучин сая дөрвөн хорин нэгэн мянга есөн зуун хорин төгрөг
	Багц 100	128,898,000.0	Нэг зуун хорин найман сая найман зуун ерэн найман мянган төгрөг
	Багц 101	88,676,000.0	Наян найман сая зургаан зуун далан зургаан сая төгрөг
	Багц 102	13,410,000.0	Арван гурван сая дөрвөн зуун арван мянган төгрөг
	Багц 103	33,616,000.0	Гучин гурван сая зургаан зуун арван зургаан мянган төгрөг
	Багц 104	4,904,000.0	Дөрвөн сая есөн зуун дөрвөн мянган төгрөг
	Багц 105	57,816,600.0	Тавин долоон сая найман зуун арван зургаан мянга зургаан зуун төгрөг
	Багц 106	7,115,000.0	Долоон сая нэг зуун арван таван мянган төгрөг

Багц 107	125,144,000.0	Нэг зуун хорин таван сая нэг зуун дөчин дөрвөн мянган төгрөг
Багц 108	22,500,000.0	Хорин хоёр сая таван зуун мянган төгрөг
Багц 109	4,000,000.0	Дөрвөн сая төгрөг
Багц 110	4,500,000.0	Дөрвөн сая таван зуун мянган төгрөг
Багц 111	41,417,600.0	Дөчин нэгэн сая дөрвөн зуун арван долоон мянга зургаан зуун төгрөг
Багц 112	1,640,000.0	Нэг сая зургаан зуун дөчин мянган төгрөг
Багц 113	8,700,000.0	Найман сая долоон зуун мянган төгрөг
Багц 114	7,438,800.0	Долоон сая дөрвөн зуун гучин найман мянга найман зуун төгрөг
Багц 115	80,740,000.0	Наян сая долоон зуун дөчин мянган төгрөг
Багц 116	84,980,000.0	Наян дөрвөн сая есөн зуун наян мянган төгрөг
Багц 117	14,750,000.0	Арван дөрвөн сая долоон зуун тавин мянган төгрөг
Багц 118	13,860,000.0	Арван гурван сая найман зуун жаран мянган төгрөг
Багц 119	615,833,612.0	Зургаан зуун арван таван сая найман зуун гучин гурван мянга зургаан зуун арван хоёр төгрөг
Багц 120	221,275,694.0	Хоёр зуун хорин нэгэн сая хоёр зуун далан таван мянга зургаан зуун ерэн дөрвөн төгрөг
Багц 121	94,716,600.0	Ерэн дөрвөн сая долоон зуун арван зургаан мянга зургаан зуун төгрөг
Багц 122	511,789,055.0	Таван зуун арван нэгэн сая долоон зуун наян есөн мянга тавин таван төгрөг
Багц 123	364,577,030.0	Гурван зуун жаран дөрвөн сая таван зуун далан долоон мянга гучин төгрөг
Багц 124	285,827,400.0	Хоёр зуун наян таван сая найман зуун хорин долоон мянга дөрвөн зуун төгрөг
Багц 125	97,367,800.0	Ерэн долоон сая гурван зуун жаран долоон мянга найман зуун төгрөг
Багц 126	79,051,850.0	Далан есөн сая тавин нэгэн мянга найман зуун тавин төгрөг
Багц 127	1,830,000.0	Нэг сая найман зуун гучин мянган төгрөг
Багц 128	35,991,300.0	Гучин таван сая есөн зуун ерэн нэгэн мянга гурван зуун төгрөг
Багц 129	5,970,400.0	Таван сая есөн зуун далан мянга дөрвөн зуун төгрөг
Багц 130	383,286,446.0	Гурван зуун наян гурван мянга хоёр зуун наян зургаан мянга дөрвөн зуун дөчин зургаан төгрөг
Багц 131	59,219,199.0	Тавин есөн сая хоёр зуун арван есөн мянга нэг зуун ерэн есөн төгрөг
Багц 132	66,072,768.0	Жаран зургаан сая далан хоёр мянга долоон зуун жаран найман мянган төгрөг
Багц 133	47,191,200.0	Дөчин долоон сая нэг зуун ерэн нэгэн мянга хоёр зуун төгрөг
Багц 134	106,222,700.0	Нэг зуун зургаан сая хоёр зуун хорин хоёр мянга долоон зуун төгрөг
Багц 135	364,944,000.0	Гурван зуун жаран дөрвөн сая есөн зуун дөчин дөрвөн мянган төгрөг
Багц 136	155,068,914.0	Нэг зуун тавин таван сая жаран найман мянга есөн зуун арван дөрвөн төгрөг
Багц 137	39,635,000.0	Гучин есөн сая зургаан зуун гучин таван мянган төгрөг
Багц 138	10,450,000.0	Арван сая дөрвөн зуун тавин мянган төгрөг
Багц 139	67,490,000.0	Жаран долоон сая дөрвөн зуун ерэн мянган төгрөг
Багц 140	102,892,400.0	Нэг зуун хоёр сая найман зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун төгрөг
Багц 141	51,100,000.0	Тавин нэгэн сая нэг зуун мянган төгрөг

Б. АГУУЛГА

ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах ажиллагаа”-ны үнэлгээний хороо Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Хувьсгалчдын гудамж, ЭХЭМҮТ, захиргааны байр, 1-р давхар Утасны дугаар: +976-11-362205, 99098796 Цахим шуудангийн хаяг: info@ncmch.gov.mn
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл. Гадаад хэл дээрх бүх материалыг орчуулгын хамт ирүүлнэ.
ТШЗ 12.4	Оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран орчуулга үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцах ба илт худал орчуулсан бол үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болно.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: Тийм - 1-46-р багцад нийлүүлэхээр санал болгосон эм нь Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн байна. Эмийн бүртгэлийн мэдээллийг LICEMED цахим системээс шалгана. Нийлүүлэхээр санал болгож буй эмийн бүртгэлийн дугаарын мэдээллийг тендерт хавсарган ирүүлнэ. Өнчин эм зэрэг ЭМС-ын тушаалаар батлагдсан бол тушаал, холбогдох баримтын хуулбарыг ирүүлнэ. - Техникийн тодорхойлолтод “дээж ирүүлнэ” гэж заасан бүтээгдэхүүнд загвар, дээж ирүүлнэ. Үүнд: • Багц 53: 1-3 дугаар бүтээгдэхүүн • Багц 54: 8-13 дугаар бүтээгдэхүүн • Багц 56: 1-9 дүгээр бүтээгдэхүүн • Багц 58: 1-4 дүгээр бүтээгдэхүүн • Багц 59: 1-4 дүгээр бүтээгдэхүүн • Багц 60: 1-5 дугаар бүтээгдэхүүн • Багц 61: 1-5 дугаар бүтээгдэхүүн • Багц 62: 1-14 дүгээр бүтээгдэхүүн • Багц 63: 2,5 дугаар бүтээгдэхүүн • Багц 64: 1-14 дүгээр бүтээгдэхүүн • Багц 65: 12-23 дугаар бүтээгдэхүүн • Багц 66: 21 дүгээр бүтээгдэхүүн • Багц 76: 1-20 дүгээр бүтээгдэхүүн • Багц 77: 1-13 дугаар бүтээгдэхүүн • Багц 78: 1-5 дугаар бүтээгдэхүүн • Багц 79: 1-8 дугаар бүтээгдэхүүн

	• Багц 80: 1-12 дүгээр бүтээгдэхүүн • Багц 81: 1-13 дугаар бүтээгдэхүүн • Багц 82: 1-5 дугаар бүтээгдэхүүн • Багц 88: 1-17 дугаар бүтээгдэхүүн • Багц 93: 1-4 дүгээр бүтээгдэхүүн • Багц 103: 1-10 дугаар бүтээгдэхүүн • Багц 105: 1-15 дугаар бүтээгдэхүүн • Багц 115: 1-9 дүгээр бүтээгдэхүүн Ирүүлээгүй бол татгалзах үндэслэл болно. - Дээжийг 2025 оны 03 сарын 27-ны өдрийн 12 цаг 00 минутаас өмнө битүүмжилсэн баглаа сав боодолтой, ирүүлсэн байгууллагын хаяг, бараа бүтээгдэхүүний жагсаалттай хүргүүлнэ. - Загвар, дээжийг шалгаж, турших ба үнэлгээний хороо мэс заслын утас, бээлий, гуурс зэрэг зарим эмнэлгийн хэрэгслийг тасаг нэгжүүдэд хуваарилан барааны үнэлгээг хэрэглэгч тасгуудаас албан бичгээр авч үнэлгээ хийхэд ашиглана. Шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендерт оролцогчид буцааж олгохгүй. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно. Бусад бүтээгдэхүүнд загвар дээж ирүүлж болно, ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Үгүй”
ТШЗ 18.1	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: Шаардахгүй Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: Шаардлагатай: 2023, 2024 онуудын аль нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 30%-с багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: Шаардана. Температурын тодорхой нөхцөл шаарддаг эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисыг горимын дагуу хадгалах, тээвэрлэх хэрэгсэлтэй байх Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: 1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2023, 2024 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь тухайн багцын батлагдсан төсвөөс багагүй байна. 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тухайн багцын батлагдсан төсвийн үнийн дүнгийн 30%-с багагүй байна. 3. Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй байх. Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Үүнд:

